

“МОНГОЛ БИЧГИЙН ҮСГИЙГ САВ, ШИМ ЕРТӨНЦТЭЙ ХОЛБОН ТАНИХ НЬ” СЭДВИЙН СУДЛАГДСАН БАЙДАЛ

Ц.Буянхшиг*, ХААИС

Abstract

The study explores the most complicated issues of teaching the alphabet of Mongolian Classical Scripts. Those are to realize the differences in the spelling and pronunciation of Mongolian Classic Scripts. For instance, it is difficult to distinguish some letters which are identical in sound, but different in spelling and to understand their special features. In combining the above mentioned features of the alphabet of Mongolian Classical Scripts with the world phenomena, the study is the attempt to explore the previous studies and sources to identify the phonological, morphological and grammatical features of each letter in the alphabet of Mongolian Classical Scripts. On the other hand, the letters were created and formed with relation to the world phenomena.

It simply studied the ancient linguistic writing forms based on the current researches. Researchers used to name the each letter of Mongolian Script by following 1) position of forming phonetics, 2) spelling and character of phonetics, 3) Letter position in the word structure, 4) letter shape respectively. In other words, language was included internationalization of linguistic practices.

Түлхүүр үг

Авиа, орон, дуудлага, үг, бүтэц, үсэглэвэр, хэлбэр дүрс

Удиртгал

Эрдэмтэн багш Чой. Лувсанжав “Монгол бичиг 7, 8-р анги” сурах бичигтээ хомбогор толгой, дэлбэн чих, сэртэн, гогцоо, дэгээ, зартиг, завьж гэх зэргээр үсгүүдийг нэрлэсэн байдаг нь чухамдаа үсэг нүдлүүлэх уламжлалт аргатай холбоотой юм. (Лувсанжав, 1986, х.25) Мөн Чой. Лувсанжав, А.Цог-Очир нарын бичсэн цагаан толгойн сурах бичигт А үсгийн хажууд алим, Э үсгийн хажууд эвэр, СА үсгийн хажууд сам, сарны зураг байдаг нь үсэг таних, тогтоох тулгуур дохионы үүрэгтэй байх бөгөөд цагаан толгой заахад ашигладаг үндсэн аргад хамаарна. Харин монгол бичгийн СА үсэг сам юм уу сарны хэлбэртэй төстэй байна гэдэг санаанаас үүтгэн, заах аргын ухаанаар баяжуулан хөгжүүлбэл бидний судалгааны ажилтай холбогдож байгаа юм. Гэхдээ нарийвчлан, тусгайлан арга болтол нь хөгжүүлсэн зүйл байхгүй юм. Проф. А. Цог-Очир “Аливаа юм болон амьтны хэлбэр дүрс, овор, хэмжээ, үйлдэл хөдөлгөөн, дуу чимээний нарийн ялгааг авианы сэлгэц, үг бүтээх дагаврын арга зэргээр дурайтал дүрсэлдэг нь монгол хүний сониуч, ажигч чанар, харааны болон сонсголын ой, дүрийн сэтгэлгээний хөгжилтэй холбоотой байна. (2015, х.188) тэмдэглэсэн байдаг.

Энэ бүхнийг нэгтгэн дүгнэвээс орчин үеийн сургалтад нэн тэргүүнд тавигдаж байгаа бүтээлчээр унших үйлийн суурь болох цагаан толгойн үсгийг нэршүүлэн зааж сургадаг өвөрмөц

сонин арга нь шавь төвтэй гэрийн сургалтаас уламжлан тогтсон байна. (Баттогтох, 1993, х.3). Өөрөөр хэлбэл, үсэг, үеийг хэлбэрээр нь шууд таньж тогтоолгохын тулд тэдгээрийг хүн амьтны бие эрхтний хэлбэр дүрстэй адилтган, “нуруу”, “гэдэс”, “шүд”, “хөл”, “сүүл”, “завьж”, “эвэр”, “гээг” гэх мэтээр нэрлэж байсан нь, нэгдүгээрт, монгол бичгийн бичлэг зүйн өвөрмөц онцлог, боломжоос үүдэлтэй, хоёрдугаарт, танин мэдэхүй, заах аргын нарийн үндэстэй байна. Үсгийн нэр нь нутаг нутагт ялгүй ялгаатай байсан боловч нийт үсгийг бүтсэн махбодын хэлбэр дүрсийн онцлогоор нь бүлэглэж, ацаг шүдэт үсэг /л, м, н/, нуман зурлагад үсэг /х, г, б, нг/, шилбэт үсэг /з, ж, йа, р, д, т/, эвэрт үсэг /ц, ч/, завжит үсэг /с, ш/ хэмээн ялган төрөлжүүлж заадаг арга эдүгээ Өвөрмонголд нэлээд хэвшилтэй байгаа юм. (Баттогтох, 1995, х.26).

Энэ бүхнийг онцлон дурдсаны учир юу хэмээвээс бидний боловсруулсан заах арга нь монгол бичгийн үсэг зүйн өвөрмөц тогтолцоо хийгээд бичлэгийн уян хатан, өргөн боломжид үндэслэсэн гэдгийг үсэг зүйн үүднээс тодруулахад байгаа юм.

Үндсэн хэсэг

Аль ч хэлний бичиг үсгийн сургалт цагаан толгойн үсэг таниулахаас эхэлдэг тул

*✉ buyankhishig471@gmail.com

бичиг үсгийн заах арга нь хэлбичгийн сургалтын анхдагч бөгөөд илүү анхаарваас зохих чухал асуудал болно.

Данзандагвын зохиосон “Зүрхний толтын тайлбар огторгуйн маань хэмээх судар оршивой”¹², Лувсанчойнхорын “Монгол үсгийн гол ёсыг тодотгогч толь хэмээх бичиг”, Агваандандарын “Монгол үсгийн ёсыг сайтар номлосон хэлний чимэг хэмээгдэх оршивой”, Лхамсүрэнгийн “Монгол үсгийн ёсыг тодорхойлон гаргасан алтан толь хэмээгдэх оршивой” зэрэг хэлзүйн уламжлалт дурсгал бичгүүд болон монгол бичгийн зөв бичих зүй, үсэг зүй, заах арга зүйн чиглэлээр бичсэн 6 диссертаци, 40-өөд өгүүлэл, 10 гаруй цагаан толгой, 30 гаруй зөвлөмж, заах аргын олон арван өгүүлэл, илтгэлийн агуулга санааг судлан үзвээс юуны урьд “ах үсэг”, “эх үсэг” буюу үндсэн долоон эгшигийг эхэлж үзээд, дараа нь гийгүүлэгч үсгийг зурлагын төстэй байдлаар нь бүлэглэн заадаг уламжлалт үеийн аргыг онцгойлон дурджээ. Үсэг үе нүдлүүлэх, цээжлүүлэх, торч түгдрэлгүй уншуулах, ижил төстэй үсгүүдийг ялган таниулах үүднээс үсгүүдийг хэлбэр дүрсээр нь титэм, шүд, шилбэ, гэдэс, нуруу гэх мэтээр нэршүүлэн заадаг уламжлал нь монгол бичгийн цагаан толгойн үсэг зохиогдсон тэр цаг үеэс эхэлсэн байна гэж үзэх үндэстэй юм. Монгол бичгийн цагаан толгойн үсгийг дөрвөн аргаар нэрлэж байсан уламжлалтай байна. Үүнд:

1. Авиа бүтэх, гарах орноор нь нэрлэх. Энэ тухай Данзандагвын зохиосон “Зүрхний толтын тайлбар огторгуйн маань”¹³ хэмээх судар оршивой”-д “Анханд таван, огторгуй, хий, гал, ус, шороо таваас а, э, нг эхлэн га, ха төрлөөрөө огторгуйн махбод ба и эхлэн жа, ша төрлөөрөө хийн махбод ба ра, йа, ча төрлөөрөө гал махбод хийгээд о, у эхлэн ма, ба, па төрлөөрөө хийгээд ва, вэ усан махбод ба да, та, на, ла, са эдгээр төрлөөрөө шороо махбод болой” (Өнөрбаян, 1997, х.15.) хэмээн үсэг тэдгээрийг дуудах цагт аль орноос төрөх байдал, 5 цул эрхтэнд хэрхэн нөлөөлдөг байдлыг харгалзан 5 ангилсан байна. Өөрөөр хэлбэл, а, э, нг, га, ха бол огторгуй махбодын үсэг гэж нэрлэсэн гэсэн үг.
2. Тухайн үсгийг дуудах байдлаар буюу авиа зүйн шинжээр нь нэрлэх. Тухайлбал, Лувсанчойнхор “Монгол үсгийн гол ёсыг тодотгогч толь хэмээх бичиг”-гээ эгшиг үсгийг хүчдэлээр нь “эр буюу чанга үсэг, эм буюу хөндий үсэг” хэмээн нэрлээд, “юуны тул тийн хэмээмү хэмээвээс, ертөнцөд эр дууны

аялгуу чанга, өгүүлэх хийн хүчин их лүгээ адил эдгээр эр эгшигийн дуунд аялгуу чанга, өгүүлэх хийн хүчин тод эрчимтэй тул болой” (Өнөрбаян, 1997, х.20.) гэсэн байна.

3. Үсгийг үгийн бүтцэд тохиолдох байраар нь нэрлэх. Данзандагва бээр “Зүрхний толтын тайлбар огторгуйн маань хэмээх судар оршивой” бүтээлдээ “Анх а,э,и,о,у,ө,ү болой. Эдгээрийг ах үсэг буюу эх үсэг хэмээх болой. Юуны тул хэмээвээс эдгээр үсэг төрлөөрөө хаа бичвээс бээр үгсийн эх болохын тул тийн хэмээн өгүүлжээ. Мөн Лувсанчойнхор “Монгол үсгийн гол ёсыг тодотгогч толь хэмээх бичиг”-т “Эдгээр 7 эгшиг үсэг нэрийн тэргүүн ямагт ирэхийн тул ахмад үсэг хэмээн” гэсэн бол Агваандандарын “Монгол үсгийн ёсыг сайтар номлосон хэлний чимэг хэмээгдэх оршивой”-д “Бус бас эдгээр долоон үсэг үгийн эхэнд бичихээс ангид дунд ба адагт бичих ёсон үгүйн тул хан үсэг ч хэмээн” (Өнөрбаян, 1997, х.8) гэжээ. Ер нь монгол бичиг заах үндсэн арга-үеийн арга гэдэг нь чухамдаа эгшиг үсгийг хэрхэн үзэхээс үүдэлтэй бөгөөд эдүгээ үеийн аргын мөн чанарыг дутуу ухаарсан зүйл хожмын үеийн цагаан толгойн сурах бичгүүдээс тодорхой мэдэгдэж байна.
4. Үсэглэвэр (үсэг бүтээж буй махбод буюу элемент)-ийг хэлбэр дүрсээр нь нэрлэх. Монгол бичгийн үндсэн зурлага, ялгах тэмдгийг аргазүйн үүднээс шинжлэн үзвээс гэрийн багш нар шавийг сургахдаа үсэг бүтээх зурлага, дүрсээс эхлэн нүдлүүлж, гарыг зүгшрүүлэн бичүүлэх зэргээр нэг үйлдлийг хэдэнтээ давтан хийлгээд, улмаар цагаан толгойн үсгээ үзэхдээ эгшиг үсгээр эхэлж, дараа нь гийгүүлэгч үсгүүдийг эгшгээр амилуулан үе бүтээн уншуулж бичүүлэх нарийн дэс дараагаар заан сургадаг байжээ. Профессор Д.Баттогтох Монгол бичгийн цагаан толгой зааж ирсэн уламжлалыг нэгтгэн дүгнэж, улмаар монгол бичгийн үндсэн зурлага, ялгах тэмдгийг хэрхэн заах мөрдлөгийг санал болгосон байдаг. “Монгол үсгийн махбодын зурлага /зурам ч гэдэг/, ялгах тэмдэг нийлээд 20 илүү буй бөгөөд тэдгээрийн ихэнх нь зөвхөн нэг үсэг бүтээх юм уу нэгийг нөгөөгөөс ялгах үүрэгтэй юм. (Баттогтох, 2013, х.137.) Мөн судлаач Т.Дашцэдэн “Монгол хэлбичиг заах аргын уламжлалын зарим асуудал” бүтээлдээ: “монгол бичгийн үндсэн махбод (зурам) гэдэгт эгшиг, гийгүүлэгч үсгийг бүтээхэд оролцдог титэм, шүд (а,э), шилбэ (и), гэдэс (о,у,ө,ү), нум

¹²Бүтэн нэр нь: “Богд Чойжисэр бээр зохиосон Зүрхэн толтын тайлбар үсгийн эндүүрлийн харангусыг арилгагч огторгуйн маань хэмээх судар оршивой”

¹³“маань” гэдэг нь санскрит буюу самгарди хэлний үг бөгөөд “нар” гэсэн утгатай.

(х), сүүл (а,э), орхиц (а,э), дусал (цэг), эвэр (л), гэзэг (м) гэх зэрэг махбод ба ялгах тэмдгийг оруулсан байна” (1968, х.6) гэжээ.

Дүгнэлт

1. Монгол бичгийн цагаан толгойн үсгийг хэлбэр дүрсээр нь хүн амьтны эрхтний хэлбэртэй адилтган нэрлэсэн нь эртний уламжлал боловч заан сургахдаа сав, шим ертөнцийн юмс үзэгдлийн хэлбэр дүртэй холбон адилтгаж байсан туршлага хомс учраас энэ талаар судалж бичсэн зүйл бараг үгүй байна.
2. Монгол бичгийн цагаан толгойн үндсэн махбодыг “титэм”, “шүд”, “гэдэс” гэх мэтээр нэрлэж, эх үсэг буюу үндсэн эгшгээс бусад гийгүүлэгч бүрийн эхэн, дунд, адагт ордог хэлбэрийг бичиж, улмаар ямар авиа үсэг болохыг хэлж дуудах байдлаар “үе”-ийн аргаар зааж байсныг эдүгээ хүртэл мөрдөж байгаа боловч эгшиг үсгийг зааж байгаа тухайд сонгодог үеийн арга гэдэгтэй таарахгүй байгаа юм
3. Монгол бичгийн цагаан толгой заах арга зүйн бүтээлүүдэд үсэг бүр үгийн эхэн, дунд, адагт хувирах ёсыг хэрхэн заах талаар тайлбарласан зүйл их боловч монгол бичгийн үсэг зүй, бичлэгийн онцлог шинжийг харгалзан, хялбар дөхөм байдлаар, тогтолцоотой заан сургах өвөрмөц арга боловсруулах шаардлагатай байгааг өнөөгийн монгол бичгийн сургалтын үр дүн бэлхнээ харуулж байна.
4. Мөн цагаан толгой заах арга зүйг хэлний агуулгын ай болох утга, бүтэц, хувиргал, соёлтой холбон судалсан зүйл өнөө хүртэл байхгүй байгаа нь уг судалгааны хэрэглээний талын нэгэн чухал үндэслэл болж байгаа билээ.

Ашигласан материал

- Баттогтох, Д. (1993). *Монгол бичгийн цагаан толгой заах зөвлөмж*. Улаанбаатар: Китаб
- Баттогтох, Д. (1995). *Монгол бичгийн заах аргын уламжлал, шинэчлэл*. Улаанбаатар: диссертаци
- Баттогтох, Д. (2013). *Монгол бичгийн гайхамшиг оршвой*. Улаанбаатар: Мөнхийн үсэг
- Буянхишиг, Ц. (2016). Сав, шим ертөнц ба монгол бичиг. *Лавай эрдэм шинжилгээний бичиг №15* Улаанбаатар
- Дашцэдэн, Т. (1968). Монгол хэлбичиг заах аргын уламжлалын зарим асуудал. *Сурган хүмүүжүүлэгч*. Улаанбаатар

Лувсанжав, Чой., Лувсандорж, Ж., Шархүү, Цэ. (1986). *Монгол бичиг 7-р ангийн сурах бичиг*. Улаанбаатар: Ардын боловсролын яамны сурах бичиг сэтгүүлийн нэгдсэн редакцын газар

Монгол Улсын Засгийн Газар. (1995). Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-2. *Монгол Улсын Засгийн Газрын 1995 оны 43-р тогтоол*. Улаанбаатар: Монгол Улсын Засгийн Газрын хэвлэл

Өнөрбаян, Ц. (ред.) (1997). *Монголхэлшинжлэлийн дурсгал*. Улаанбаатар: Боловсрол судлалын үндэсний хүрээлэнгийн хэвлэл

Цог-Очир, А. (2015). Монгол хэлний хэлзүйн байгуулалд туссан монгол хүний сэтгэлгээний онцлог. *Монгол судлалын чуулган, №18(53)*. Улаанбаатар